



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/06

Мандалговь

Байгууллагын өмч хамгаалах  
байнгын зөвлөл байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 06 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Орон нутгийн өмчит хуулийн этгээд болон сумын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга: Байгаль орчны салбарын бодлогын хэрэгжилт, хүний нөөц, дотоод хяналт шалгалт, хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн

Гишүүн: Ерөнхий нягтлан бодогч  
Биологийн олон янз байдал, тусгай хамгаалалттай газар нутаг, төрийн бус байгууллага, хариуцсан мэргэжилтэн

2.“Орон нутгийн өмчит хуулийн этгээд болон сумын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын дагуу ажиллахыг зөвлөлийн гишүүдэд, зөвлөлийн үйл ажиллагааг тухай бүр тайлагнаж ажиллахыг зөвлөлийн даргад тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  Н.ГАНТУЛГА



Tuhsaal A.docx

482401017